

НИЙТИЙГ ХАМАРСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕИЙН ХЭВ ЖУРМЫН ХАМГААЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES ON PUBLIC ORDER POLICING OF COMMUNITY- BASED EVENTS



Б.БАЯНМӨНХ

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хошууч

BAYANMUNKH B.

Assistant professor of Police administrative
department, Police school, Law Enforcement University, Police major

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд 2 үндсэн асуудлын талаар дурдсан болно. Тухайлбал, а) Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн эх сурвалж нь нийгмийн дэг журам, нийгмийн хэв журам, нийтийн хэв журам гэсэн 3 үндсэн ухагдахуун дээр тодорхойлогдож байгаа талаар, б) Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн суурь нөхцөл нь нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа юм гэдгийг цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны арга, хэлбэрт үнэлэлт, дүгнэлт өгсөн тухай дурдсан болно.

Abstract: This article analyses some critical issues on public order policing and maintaining crowd management in the context of events that are staged for members of different types of communities. Therefore, this research aims to emphasize the public order policing of community psychology and capability of crisis negotiation/communication skill during the major events.

Accordingly, above mentioned two key considerations are offered as effective for the police operation during community-based events through maintaining community safety and public order that preventing of crime and enabling police power without using any force and firearms.

Түлхүүр үгс: Сэтгэл хөдлөл, анхаарал, сэтгэл зүй, тохиролцоо, нөхцөл байдал.

Key words: Emotions, attention, psychology, negotiation, situation.

Үндсэн асуудал: Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг ойлголт нь нэлээн өргөн хүрээтэй ойлголт юм.

Нийтийг хамарсан арга хэмжээ гэдэг нь хүмүүсийн улс төр, бие бялдар, оюуны хэрэгцээг хангах зорилгоор тэдгээрийн эрх ашигт нийцсэн олон түмний оролцоотойгоор явагдаж байгаа иргэдийн хүний эрх, эрх чөлөө хамгаалах өөр хоорондоо харилцах хэлбэр бие хүн, хамт олон, нийгэм бүхэлдээ үзэл бодол, үйл хөдлөл, чиглэлээ нэгтгэх арга хэрэгсэл болсон зохион байгуулалттай үйлдлийн хэлбэр

мөн.¹

Мөн зарим судлаачид арай өөр байдлаар тодорхойлсон байдаг байна. Тухайлбал, олныг хамарсан арга хэмжээ гэдэг нь олон тооны иргэдийг оролцуулсан, тэдний хэрэгцээ, ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн, нийгмийн харилцаан дахь бие хүн, бүлэг, хамт олны эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлж буй зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц юм.²

¹ Ж.Таванжин. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ., 2006. 228 дахь тал.

² Л.Билгээ. Цагдаагийн үйл ажиллагааны арга зүйн зарим асуудлууд. УБ., 2009. 100 дахь тал



хэмээн тодорхойлсон байдаг байна.

Нийтийг хамарсан арга хэмжээнд урлаг, соёл³, спорт⁴-ын арга хэмжээ, тэмдэгдэлт үйл явдлууд гэх мэт маш төрөл, хэлбэртэйгээр тодорхой зорилгын хүрээнд зохион байгуулагдаж байгаа иргэд, олон нийтийг өргөнөөр хамруулсан нийгмийн шинж чанартай арга хэмжээнүүд хамаардаг байна.

Олон нийтийг хамарсан арга хэмжээний үндсэн шинж нь:

- Нэгдсэн зохион байгуулалттай;
- Тодорхой зорилго дэвшүүлсэн;
- Эрх бүхий байгууллагын шийдвэр, зөвшөөрөлтэй байх;
- Тодорхой газар орчинд явагдах;
- Олон хүн арга хэмжээнд хамрагдсан байх;

Нийтийг хамарсан арга хэмжээг дараах байдлаар төрөлжүүлэн ангилж болохоор байна. Тухайлбал:

Агуулгаар нь:

- Нийгэм, улс төрийн арга хэмжээ
- Жагсаал, цуглаан, улсын баяр наадам⁵, УИХ, Ерөнхийлөгчийн болон бусад улс төрийн сонгууль, олон улсын болон улс, бүсийн чанартай томоохон хурал, зөвлөлгөөн, төлөөлөгчидтэй хийх уулзалт г.м.

•Соёл, урлагын арга хэмжээ

- Зугаалга, фестиваль, шоу, мэргэжлийн баяр, соёл олон түмний арга хэмжээ, урлагын тоглолт

•Биен тамир⁶, спортын арга хэмжээ

- Спартакиад, олон улс, улс, бүс, байгууллагын хэмжээнд зохион байгуулагдах төрөл бүрийн спортын уралдаан, тэмцээн;

•Захиргааны шинжтэй арга хэмжээ

-Байгалийн гамшиг, гэнэтийн болон

³ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 476 дахь тал. Хүн төрөлхтөний үйлдвэр, нийгэмлэг, оюун ухааны талаар гаргасан ололтын цогц.

⁴ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 485 дахь тал. Хүний бие махбодыг чийрэгжүүлэхийн тулд хийх биен тамирын дасгал.

⁵ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 389 дэхь тал. Наадам гэдэг нь олноороо хийж баясах, цэнгэл, зугаа гэсэн агуулгатай үг юм.

⁶ “Биеийн тамир” гэж нийгмийн соёлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний идэвхийг сайжруулах зорилгоор оюуны болон материаллаг үнэт зүйлийг бий болгох үйл ажиллагааг;

давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, сургууль, цэцэрлэгийн ойролцоох гэрлэн дохио, гарцаар зам гарахыг зохицуулах, байгаль орчинг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, байгуулах, засварлах гэх мэт;

Нийтийг хамарсан арга хэмжээний бусад төрөл

Ач холбогдлын хамрах хүрээгээр нь:

- Олон улсын
- Улсын
- Бүсийн
- Орон нутгийн
- Тодорхой байгууллага, аж ахуйн нэгжийн

Явагдах цаг хугацаагаар нь:

- Байнгын
- Үе үе хийгддэг
- Давтагдах
- Цаг үеийн шинжтэй

Арга хэмжээ явагдах газраар нь:

- Зориултын барилга байгууламж
- Гудамж талбай, олон нийтийн газар
- Хөдөө, хээр гадаа

Иргэдийн оролцох боломжоор нь:

- Хүн бүхэн чөлөөтэй оролцдог
- Хязгаарлагдмал тоотойгоор оролцдог

•Зөвхөн тодорхой хүрээний хүмүүс оролцох

Үүсэх эх үүсвэрээр нь:

- Урьдчилан төлөвлөгдсөн
- Төлөвлөгдөөгүй /тодорхой нөхцөл байдлын улмаас хийх шаардлага гарсан/

•Аяндаа бий болсон

Зохион байгуулж буй эх үүсвэрээр нь:

- Төр, засгийн санаачлага, шийдвэрээр

•Улс төрийн нам, эвсэл, бүлгийн санаачлагаар

- Төрийн тодорхой салбар

байгууллагын санаачлагаар /эрүүл мэндийн, нийгмийн халамжийн, хүмүүнлэгийн г.м/

•Төрийн бус байгууллагын санаачлагаар

•Хэсэг бүлэг иргэдийн хүсэл, санаачлагаар

Цагдаагийн байгууллага нь “Цагдаагийн албаны тухай хууль”-аар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээсэн, байнгын бэлэн байдалд ажилладаг хууль сахиулагч байгууллага билээ.

Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллага нь өөртөө төрөл мэргэжлийн олон албадыг багтаасан, Монгол Улсын хууль сахиулах салбарын нэг томоохон нэгж болохын хувьд хууль тогтоомжийн хүрээнд төрийн болон төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг засаглан захирах, шаардлагатай тохиолдолд төрийн албадлага хэрэглэх эрх эдэлдэг онцлог бүхий байгууллага билээ.

Цагдаагийн байгууллага нь гудамж талбай, олон нийтийн газарт бүлэглэн танхайрах явдлыг гаргуулахгүй байх, хориглосон газар хийгдэж байгаа болон зөвшөөрөлгүй хууль бус жагсаал цуглааныг албадан тараах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед түүнийг таслан зогсоох, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдал

эрх, эрх чөлөөг ханган ажиллаж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй билээ.


2005-2012 оны хооронд Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан нийтийг хамарсан томоохон арга хэмжээнүүдийг графикаар харуулбал:

Гэвч өнөөдөр янз бүрийн шалтгаан, хүчин зүйлийн улмаас гудамж, талбай, олон нийтийн газарт хууль зөрчиж улс төр хийх, шаардлагаа хууль бус аргаар илэрхийлж, бусдыг хууль бус ажилд өдөөн турхирах, иргэдийн болон төрийн алба хаагчдын эрх чөлөөнд халдах, хувийн болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэн гэмтээх, устгах, шатаах, иргэдийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөөнд бүдүүлгээр халдах, олон нийтийн болон тээврийн хэрэгслийн зорчих хэсгийг хаах, төрийн тусгай хамгаалалтын бүсэд дур зоргоор нэвтэрч танхайрах зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл гарсаар байна.

Энэхүү нийгмийн сөрөг үзэгдлийг гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд нэн даруй таслан зогсоож, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аж ахуйн нэгж, байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх нь Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үндсэн үүрэг билээ.

Өнөөдөр манай улсад улс төр, нийгэм, соёл урлаг, захиргааны шинжтэй маш олон арга хэмжээ зохион байгуулагдах босон бөгөөд тэр бүхэнд цагдаагийн байгууллага нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн хэвийн явагдах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ.

Гэвч уг нийтийг хамарсан арга хэмжээ явагдах үед үүсч болзошгүй сөрөг нөхцөл байдлуудыг урьдчилан харж, хамгаалалтын явцад үүсч болох хүндрэлүүдийг бий болохоос өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг





ХҮҮЛЬ
САХИУЛАХҮЙ

цаг алдалгүй авч хэрэгжүүлэх үүрэг цагдаагийн байгууллагад ирдэг.

Цагдаагийн байгууллага олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үед гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх хэв журмын хамгаалалтыг зохион байгуулахдаа дараах асуудалд анхаарлаа хандуулах шаардлага тулгардаг. Тухайлбал:

Олон нийтийн сэтгэл хөдлөл:

Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үед цугларсан иргэд, олон нийт нэг асуудалд анхаарлаа төвлөрүүлэх чадвартай байдаг. Арга хэмжээний үед хэн нэгэн этгээдийн үйл ажиллагааны нөлөөлөлд бусад хүмүүс өртөх магадлал өндөр байдаг.

Өөрөөр хэлбэл хэн нэгэн этгээдийн сэтгэл хөдлөл бусдын сэтгэл хөдлөлд нөлөөлсөн, халдварласан бол энгийн үеэс хамаагүй хүчтэй, далайцтай нөлөөлөлд автах магадлал өндөр байдаг байна.

Томоохон арга хэмжээний үед зарим нэг хүн улс төр, эдийн засгийн болон өөр бусад шалтгааны улмаас бус, харин гагцхүү өөрийн нөхцөл байдлыг бусдад илэрхийлэх, мэдрүүлэх, бусдын анхаарлыг өөртөө татах, хувийн ашиг сонирхлоо дээгүүрт тавьж, арга хэмжээний зорилгыг өөрчлөх байдлаар төвөг учруулдаг.

Тийм хүмүүс сэтгэл зүйн хувьд бусдын анхааралд өртөж, бусдыг удирдан дагуулах, зохион байгуулах, өөрийнхөө давуу талаа бусдад мэдрүүлэх, ухаантай, цэцэн цэлмэгээ гайхуулах, зүрх зоригтой гэдгээ олон нийтэд харуулахыг хүсдэг.

Ийм сэтгэл хөдлөлд хөтлөгдсөн хүн хуулийг үл хайхарч, олон нийтийн ашиг сонирхлыг үл хүндэтгэж, уг арга хэмжээг хутган үймүүлдэг бөгөөд дараах зан үйлийн сөрөг хэлбэрийг үзүүлдэг байна. Тухайлбал:

-Арга хэмжээг нөгөө талаас удирдан зохион байгуулахыг оролдох;

-Бусдыг ямар нэгэн сөрөг үйлдэл хийхэд чиглүүлэх, хатгах, ятгах;

-Бусдыг уриалан дуудаж сөрөг үйлдэлд өдөөн турхирах, зоригжуулах;

-Хэв журмын хамгаалалтын эгнээ рүү түлхэх, шүгэлдэх, бусдыг уриалан орилж хашгирах, хөөргөх;

-Хамгаалалтын бүсэд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид руу үг хэлээр доромжлох, дайрч давшлах;

Түүнчлэн олныг хамарсан арга хэмжээний үеэр зарим хүмүүс өөрсдийн хүнд хэцүү амьдрал, туулж буй зовлон бэрхшээлийг төр засгийн бодлого шийдвэр, амьдарч буй нийгмээс болж байгаа гэсэн хандлагаас үүсэлтэй бухимдлаа төр, засаг болон нийгмийг хараан зүхэх, тодорхой зарим төрийн өндөр албан тушаалтны нэрийг хэлж, дайрч давшлах, хэл амаар доромжлох, орилж хашгирах, ёс зүйгүй үйлдэл гаргах байдлаар илэрхийлэх явдал тохиолддог.

Өөрөөр хэлбэл олон хүмүүсийн дунд өөрийн бодож явдаг зүйлээ орилж хашгиран хэлэх замаар олон нийтийг буруу тийш хөтлөх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх нөхцлийг бүрдүүлэх хүндрэлийг үүсгэдэг байна.

Мөн олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдах явцад зарим оролцогчид өөрийнх нь ашиг сонирхлыг хөндөж, ялгаварлан гадуурхсан гэж үзсэний үндсэн дээр зохион байгуулагч хүмүүс болон тэдэнтэй холбоотой хэн нэгнийг эсэргүүцэх, үйл ажиллагааг нь тасалдуулах үйлдлийг гаргадаг байна.

Тухайлбал, уралдаан тэмцээний үеэр буруу шүүсэн гэж үзэн шүүгчдийг хэл амаар доромжлох, ундаа усны сав шидэх, хог цаасаа шидлэх гэх мэт.

Тиймээс олныг хамарсан арга хэмжээний аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах хамгаалалтыг удирдан зохион байгуулж буй цагдаагийн удирдлагын баг /Шуурхай удирдлагын штаб/ нь нийтийн сэтгэл зүйн байдлыг анхааралдаа авч, тэндээс ирж буй мэдээлэлд тогтмол дүн шинжилгээ хийж, үүсч болзошгүй сөрөг нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэх

арга хэмжээг цаг алдалгүй авах нь уг нийтийг хамарсан арга хэмжээ хэвийн явагдах үндэс болно.

Тохиролцоо:

Энэ нь олныг хамарсан томоохон арга хэмжээний хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой ажиллагаа билээ.

Гэхдээ тохиролцоог уг олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээг зохион байгуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хийх бөгөөд гол нь хуулийн дагуу зохион байгуулах, зөрчигдөх тохиолдолд албадан тараах, арга хэмжээний үндсэн зорилго өөрчлөгдсөний улмаас үүсэн гарах үр дагавраас бий болох хариуцлагыг хүлээх нөхцлийг тусгасан харилцан, хамтран ажиллах санамж бичиг хийх замаар зохицуулна.

Тохиролцоог хийхдээ дараах асуудлыг сайтар анхаарах шаардлагатай юм. Тухайлбал:

-Тохиролцоог мэргэшсэн, туршлагатай алба хаагчдаас бүрдсэн баг хийх

-Тохиролцоог урьдчилан бэлдсэн ажлын хүрээнд явуулах

-Тохиролцоо хийх эсэх нь мэдэгдэхгүй, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал бий болсон ч тохиролцооны бэлтгэлийг бүрэн хангасан байх

-Тохиролцоог хийхдээ тухайн хүн бүр дээр өөр өөр стратеги тактикийг баримталж хийх тул сэтгэл зүйн, гүйцэтгэх ажлын шугамаар авагсан мэдээ, мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг тооцох

Түүнчлэн олныг хамарсан томоохон арга хэмжээний үеэр бусдыг уриалан дуудах, турхирах, олон нийтийн дунд эмх замбараагүй байдал үүсгэх, арга хэмжээг тасалдуулах үйлдлийг гардан гүйцэтгэж байгаа, удирдан зохион байгуулах санаачлагыг гаргаж байгаа этгээдтэй хийх тохиролцоо бол огт өөр ажиллагаа байна.

Энэ тохиролцоог дор дурдсан үйлдэл,

үйл ажиллагаа явуулж буй иргэн, хэсэг бүлэг этгээдүүдтэй хийнэ. Тухайлбал:

-Арга хэмжээг тасалдуулах, уг арга хэмжээний зорилгын эсрэг, хүрэх үр дүнг саармагжуулах сөрөг ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлж буй этгээд, эсхүл хэсэг бүлэг этгээдүүдтэй;

-Бусдыг өдөөн турхирч, олон нийтийн анхаарлыг өөртөө татаж уриалан дуудаж байгаа этгээд, хэсэг бүлэг иргэдтэй;

-Бусдыг дайрч давшлах, хэл амаар доромжлох, орилж хашгирах, ёс зүйгүй үйлдэл гаргах иргэдтэй;

Цагдаагийн байгууллагаас дээрхи иргэд болон хэсэг бүлэг иргэдтэй хийх тохиролцоог зохион байгуулагчидтай хийх тохиролцооноос арай өөр хэлбэр, арга тактикаар хийнэ. Тохиролцоог дараах мэдээллийг олж аван дүн шижилгээ хийсний дараа хийнэ. Үүнд:

-Тухайн иргэний зан байдал, сэтгэл зүйн онцлог;

-Үйл хөдлөлийнх арга хэлбэр;

-Сөрөг үйл ажиллагааных нь хамрах хүрээ;

-Бусдын сэтгэл зүйд нөлөөлж буй байдал;

-Сөрөг үйлдлийнх нь эцсийн зорилго, хүрэх үр дүн;

-Тухайн сөрөг үйлдэлд дэмжлэг үзүүлэн, асуудлыг хөөргөж байгаа этгээдүүдийн талаархи мэдээлэл;

-Ашиглаж байгаа техник, хэрэгслийн талаархи мэдээлэл;

-Санхүүгийн эх үүсвэрийнх нь талаархи мэдээлэл;

-Бусад мэдээлэл;

Тохиролцоо үр дүнд хүрэхгүй тохиолдолд хууль зөрчсөн болон бусдыг өдөөн турхирч, олны анхаарлыг татсан хүмүүсийг уг нийтийг хамарсан арга хэмжээнээс албадлага хэрэглэн авч явахдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай.

а.Зөрчил үйлдсэн этгээдийг салган тусгаарлаж, авч явахдаа бусад хүмүүс дагахгүй байх арга хэмжээ авах; /саад, хаалт, хориглолт хийх/



МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УНДСЭН
СЭМЖ

b.Зөрчилтэй этгээдийг олон нийтийн дундаас авч явахдаа хүч хэрэгслийг хангалттай хэмжээгээр бүрдүүлсний дараа хийх;

c.Зөрчил гарсан этгээдийн хийсэн хууль зөрчсөн үйлдлийнх нь талаархи нотлох баримтыг бүрдүүлсэн байх;

d.Олон нийтийн сэтгэл зүйд нөлөөлөх хүч хэрэглэсэн сөрөг арга хэлбэрээр зөрчил гаргасан этгээдийг тусгаарлан саатуулах ажиллагааг явуулахгүй байх

ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллага нь нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үеийн хэв журмын хамгаалалтыг зохион байгуулахдаа уг арга хэмжээний зорилго, хамрах хүрээ, зохион байгуулагдах нутаг дэвсгэр, ашиглагдах техник хэрэгслийн талаар мэдээлэл цуглуулах, зохион байгуулагчидтай харилцан, хамтран ажиллах талаар тохиолцох, хамгаалалтанд ажиллах цагдаагийн хүч хэрэгслийг зөв хувиарлах, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлуудаас гадна оролцогчдын сэтгэл хөдлөл, түүний хамрах хүрээг тодорхойлох явдал хамгийн чухал ажлуудын нэг гэж үзэж байна.

Түүнээс гадна нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үеэр уг ажиллагааг тасалдуулах, сөрөг ажиллагаа зохион байгуулах, эмх замбараагүй байдал үүсэх магадлал бүхий мэдээллийг гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан тохиолдолд уг асуудалд холбоотой иргэн болон хэсэг бүлгийн удирдлагатай урьдчилан тохиролцоо хийх нь үндсэн арга хэмжээний хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх чухал үр нөлөөтэй арга хэмээн үзэж байна.

Тиймээс нийтийг хамарсан томоохон арга хэмжээний үеийн хэв журмын хамгаалалтын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах саналыг гаргаж байна.

1.Нийтийн сэтгэл хөдлөлийн хэв шинжийг судлан дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн багийг сургаж бэлтгэх;

2.Цагдаагийн алба хаагч бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөр, тэр дундаа “Нийтийн сэтгэл судлал” чиглэлийн сэдвийг “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тактик” хичээлийн үндсэн агуулгад нэмж тусгах замаар алба хаагч бүрийг мэргэшүүлэх;

3.Шуурхай удирдлагын штабын дэргэд мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн тусгай бүлгийг байгуулж, ажил үүргийг тодорхойлж, ажиллагаанд байнгын бэлтгэлтэй байлгах;

4.Шуурхай удирдлагын штабын дэргэдэх тусгай бүлгүүдийн алба хаагчдад тохиролцоо, ач холбогдлыг тайлбарлан таниулах замаар мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг сонгуулиас өмнө зохион байгуулж явуулах.

Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн, Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч Б.Энхболд